

“Оллоо ХК”-ий 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн

ээлжит хурлын протокол

2026.02.27

Улаанбаатар хот

2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 16:00 цагт биеэр хүрэлцэн ирж оролцсон 10 хувьцаа эзэмшигч, Онлайнаар оролцсон 2 хувьцаа эзэмшигч нийт 12 хүний бүрэлдэхүүнтэйгээр эхэлж 18:20 минутад дуусгавар болов. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар ТУЗ-ын дарга П. Бүүвэйбаатар, нарийн бичгээр ТУЗ-ын хараат бус гишүүн Г. Энхтөр нар ажиллав. Төллогын комиссын даргаар Ц. Энхтөр, гишүүнээр М. Ганди, У. Нарангэрэл нар ажиллав.

ТУЗ-н дарга Бүүвэйбаатар: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга миний бие хурал эхэлснийг мэдэгдэж байна. Оллоо ХК-ын гол хувьцаа эзэмшигч болох Наранзул, Төртүвшин нарт юуны өмнө талархлаа илэрхийлье. Мөн манай компанийн гүйцэтгэх захирлаар ажиллаж буй Уламбаяр нь гурван жилийн хугацаанд шинийг санаачилж, манлайлан ажиллаж байгаа учир энэ хугацаанд хийсэн бүх ажлын төлөвлөгөөний биелэлт энэ тайлант жилд үр дүн гарна гэж маш их найдаж байна. ТУЗ-ын хараат бус гишүүдэд нэр дэвшигчдийг танилцуулав. Компанийн засаглалын сайн туршлагыг өөрсдийн компанид нэвтрүүлэн ажиллахын тулд ТУЗ-ын сонгуулийн нэр дэвшигчдийг Хөрөнгө оруулагчид болон ТУЗ-ын гишүүдийн санал, зөвлөмжийг харгалзаж үзсэн.

Өнөөдрийн хурлын хэлэлцэх 1 дүгээр асуудал: 2025 оны Үйл ажиллагааны болон Санхүүгийн тайланг та бүхэндээ танилцуулж байна. Энэхүү тайланг гүйцэтгэх захирал танилцуулна. Мөн 2025 оны тайлант жилд Ноогдол ашиг хуваарилахгүй тухай асуудлыг хэлэлцэх болно.

ТУЗ-н дарга П. Бүүвэйбаатар: ТУЗ-ын 2025 онд нийт 9 хүний бүрэлдэхүүнтэй ажилласан ба ТУЗ-ын ээлжит болон ээлжит бус хурлын ирц хангалтгүй байсан. Түүнээс улбаалан бид зохицуулах байгууллагад хандан ТУЗ-ийн түр гишүүн томилох тухай хүсэлт илгээсэн боловч хугацаа давчуу учир ТУЗ-ийн нийт гишүүдийг шинээр батлах нь зүйтэй гэсэн чиг үүргийг авч ажиллаж компанийн тухай хуулийг баримтлан Бүүвэйбаатар миний бие ТУЗ-ийн ноогдол ашиг хуваарилахгүй байх энэ тогтоолыг баталсан.

Гүйцэтгэх захирал Г. Уламбаяр: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Тараасан материалд дурдсан мөн дэлгэц дээр гарч буй 2025 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайланг танилцуулах гэж байна. 2025 онд бид ТУЗ-ын 9 гишүүдтэй, гүйцэтгэх захирал, нягтлан бодогч, вэб админ гэсэн бүрэлдэхүүнтэй ажилласан. Үйл ажиллагааны, вэбсайт, фейсбүүк пэйжийн хандалтын өсөлтийн статистикийг тайлагнав. Санхүүгийн тайлангийн хувьд тайлант жилд алдагдалтай ажилласан тул ноогдол ашиг хуваарилахгүй байх тухай шийдвэр гарсан. Мөн МҮОНРТ, Голомт, ХӨСҮТ гэх 3 байгууллагатай хамтран ажиллаж 77.9 сая төгрөгийн орлоготой ажилласан.

ТУЗ-н дарга П. Бүүвэйбаатар: 2025 оны тайлант жилд эргэлтийн бус хөрөнгийг нэмэгдүүлсэн. 2024 онд вэбсайтын шинэ хувилбар гаргасан. Бусад мэдээлэл технологийн байгууллагатай хамтран ажиллаж өөрсдийн дата баазыг хадгалах, бүртгэх гэх мэт сар бүр тогтмол үйлчилгээ авч ажиллаж үзсэн. Энэ нь зардлыг өсгөж, хэрэглэгчийн тоог бууруулахад голлох нөлөө үзүүлсэн. Фейсбүүкийн хэрэглээ өндөр болсон. 2020 оноос хойш хүн бүр мэдээллийн сайтуудтай хамтран ажиллах гэхээсээ илүү сошиал хаягууд дээрээ өөрсдөө мэдээгээ тавьдаг болсноос шалтгаалан хамтран ажиллах байгууллагын тоо цөөрч хамтран ажиллаж байсан байгууллагууд хамтран ажиллахаасаа татгалзсан нь манай салбар хүндхэн нөхцөлд байгааг харуулсан том жишээ болсон. Та бүхэн тайлан дээр асуулт болон санал хэлээрэй.

Санал, хүсэлт байхгүй.

ТУЗ-н дарга П. Бүүвэйбаатар: Асуудал 2,3-г хэлэлцье. Гүйцэтгэх захирал 2026 оны төсөв, төлөвлөгөөг танилцуулна.

Гүйцэтгэх захирал Г. Уламбаяр: Одоогийн байдлаар бидний хийж хэрэгжүүлээд явж байгаа төсөл бол Оллоо Апп байгаа энэ апп бол фэйсбүүкийн монгол хувилбар гэж ойлгож болно. Дотроо 5 төрлийн хэсэгтэй. Мөн багш робот болон малчин робот гэсэн том төслүүдийг хийж хэрэгжүүлэхээр байна. Ялангуяа Оллоо Аппыг онцолмоор байна. Хиймэл оюун ухааны тусламжтайгаар энэ апп дээр бичлэг үзэх, зар оруулах, санхүүгийн үйлчилгээ авах гэх мэт олон төрлийн үйлчилгээг нэг дороос авах боломжыг олгож байгаа цогц бүтээгдэхүүн байна. 2026 онд 3-р хувилбарыг 6 сарын 1-нд багтаан гаргах төлөвтэй байна. Та бүхэн гар утсан дээрээ татаад сонирхоод үзээрэй. Роботын төсөл одоогоор судалгааны түвшинд явж байна.

Дээрх ажлын гүйцэтгэлийг хангахын тулд 2026 оны төсөв дээр нэмэлт зардлууд үүсэж байгаа. 2025 онд 3 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байсан бол энэ жилээс 10-14 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Аппликейшныг хийж буй компани маань австралийн компани байгаа. Энэ тайлант жилд аппликейшныг бүрэн хийж дуусгаж, робот төслүүдийн судалгааны ажлыг бүрэн дуусгах төлөвлөгөөтэй ажиллаж байна. Энэ тайлант жилийн 9 сард аппликейшн бүрэн ажиллагаанд ороход 12 сар хүртэл хугацаанд 9 тэрбум төгрөг хүртэл орлого олох төлөвлөгөөтэй байна.

2026 оны төсвийг тоон дүнгээр танилцуулав.

ТУЗ-н дарга П. Бүүвэйбаатар: Та бүхэнд асуух асуулт байна уу?

ТУЗ-н гишүүн А. Цэвэлсүрэн: Санхүүгийн тайланд 26 тэрбум төгрөг төсөвлөсөн байна. Энэ мөнгөний эх үүсвэрийг яаж босгох төлөвлөгөөтэй байна вэ?

Гүйцэтгэх захирал Г. Уламбаяр: Бид хөрөнгө оруулалт татах мөн 9 сараас аппликейшн бүрэн болсон тохиолдолд хувьцаа нэмж гаргах төлөвлөгөөтэй байна.

ТУЗ-н гишүүн А. Цэвэлсүрэн: Хувьцаа босгоход та бүхэн хувьцаа эзэмшигчдээсээ санал асуух уу, ТУЗ-аар шийдэх үү?

Гүйцэтгэх захирал Г. Уламбаяр: Тэгнэ. Хувьцаа Эзэмшигчдийн Хурал төвлөж, санал авна.

ТУЗ-н хараат бус гишүүнд нэр дэвшигч Н. Эрдэнэбаяр: Одоогийн байдлаар хөрөнгө татсан уу?

Гүйцэтгэх захирал Г. Уламбаяр: Оллоо аппликейшныг 1.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт олж эхлүүлсэн байгаа. Төлөвлөгөөний дагуу 9-р сард бүрэн дуусгаж Оллоо ХК-дийн өмч болгон шилжүүлхээр төлөвлөж байна. Нэмэлтээр компани маань та бүхэндээ санал тавьж энэхүү хурлыг хийж, компанийн нөөц боломж бололцоог танилцуулан 2026 онд хийгдэх ажлыг дэмжин ажиллах санал тавьж байгаа юм.

ТУЗ-н дарга П. Бүүвэйбаатар: Манай захирал өөрөө хийж бүтээж, энэхүү ажлыг одоогийн түвшинд хүргэсэн байна. ТУЗ-ын хурлын ирц бүрдэхгүй байснаас шалтгаалан хуулийн хүрээнд ажил үүргийг үнэн зөв бодитой хүргэх үүднээс хийгдсэн ажлуудыг танилцууллаа. Бидний одоогийн бизнес технологийн үйл ажиллагаа руу чиглэж байгаа нь сэтгүүл зүйн салбар үнэгүйдэж фейсбүүкээр мэдээллийг хүмүүс хүлээн авахтай холбогдуулаад энэ хоёр салбарыг хослуулан ажиллах боломж байгааг илтгэж бид өөрсдийн аппликэйшнээр дамжуулан мэдээлэл түгээх, бизнес эрхлэгчдийг дэмжих, нийгэмд фейсбүүкийн монгол хувилбар болгож хүргэх гэж байна. Бид мөн Хувьцаат Компани учир олон талаараа давуу талтай байна. Мөн бидний хувьцааны үнэ өснө гэсэн итгэл бидэнд байна. Роботуудын тал дээр монголд одоогоор хийгдэж буй ажил, эхлүүлсэн ажил байхгүй гэж бодож байна.

ТУЗ-н хараат бус гишүүнд нэр дэвшигч Ганбаяр: Энэ роботууд нь 1 төрлийн робот дээр 2 үйлдэл гэсэн үг үү? Малчин, Багш гээд 2 төрлийн робот байна гэсэн үг үү?

ТУЗ-н дарга П. Бүүвэйбаатар: Тусдаа робот байгаа малчин робот бол мал маллана гэсэн үг. Хятад улсын жишгийг даган Оллоо Робот гэж нэрлээд монголд оруулж ирнэ, хиймэл оюун ухаан дээр суурилсан байна. Манай зүгээс монголын 10-н хиймэл оюун ухааны компанитай холбогдож судалгаа хийсэн ба БНХАУ-д очиж үйлдвэрлэх боломжтой гэсэн хариуг авсан. Малчин робот нь дан мал маллахаас гадна, бэлчээрийн бүх асуудлыг хиймэл оюун ухаан дээр суурилан дүгнэлт гаргаж шийдэх боломжтой. Малчдын ажлыг хөнгөвчлөх зорилготой байна. Багш робот бол одоогийн нийгэмд хамгийн чухал гэж бодож байна. Оллоо ХК бол 3 жилийн дараа эргэн ирэлт хийж технологийн шинэ бүтээгдэхүүнийг монголд нэвтрүүлэх чинхүү хүсэлтэй байгаа гэдгийг хэлмээр байна. Энэхүү хурал нь хувьцааны тоог үл хамааран бүх хувьцаа эзэмшигчдэд танилцуулж мэдээлэл хүргэх, санал сонсох, зөвшөөрөл авах зорилготойг дахин дахин хэлмээр байна. Мөн бид ШУТИС-тай хамтран ажиллахаар төлөвлөсөн байна.

Гүйцэтгэх захирал компанийн шинэчилсэн лого, роботын зураг болон NFC-тэй түлхүүрийн оосрыг танилцуулж, туршив.

ТУЗ-н дарга П. Бүүвэйбаатар: Апплишэйшныг орж танилцуулав. Манай хуучин лого 20 жил болсон учир шинэчилж хийсэн ба Алганд багтаасан Монгол гэсэн уриатайгаар аппликэйшн дээр эхний нүүр эхэлнэ. Бүх төрлийн мэдээллийг өөрийн утсаар дамжуулан авах боломжийг хэрэглэгчдэд хүргэж байгаа бөгөөд урамшууллын оноо цуглуулах боломжтой 5 минут тутамд зар сурталчилгаа явна. Мэдээ мэдээллийг унших, сонсох, үзэх бүрд урамшууллын оноо цугларна. Орчин үеийн дэлгэцийн шийдлийг нэмж оруулсан ба Tiktok-с жишээ авсан. Бид мэдээний сайтуудын мэдээллийг үнэн зөв, бодитойгоор хүргэхийн тулд шүүж нийтэлж байна. Манай байгууллагын ажилчид сэтгэл зүрх ур чадвараа шингээн ирээдүйд үнэ цэнэ бүтээх бүтээлийг хийж байна. 3 сараас маркетинг үйл ажиллагааг илүү нэмэгдүүлж ажиллана. Өнөөдрийн хурлаар ТУЗ-г томилох нь нэн түрүүний ажил байна.

ТУЗ-н гишүүн Г. Наранзул: Маркетингийн ажлыг хурдацтай хүргэх нь зүйтэй гэж үзэж байна. Эхнээсээ хэрэглэгчид дээ хүргээд, зах зээлд нийлүүлэх нь зүйтэй гэж бодож байна.

Гүйцэтгэх захирал Г. Уламбаяр: Бид 26 тэрбум төгрөгийг 2 жилийн хугацаанд нөхөн олох боломжтой гэж харж байна.

ТУЗ-н дарга П. Бүүвэйбаатар: Санал, асуулт байна уу?

ТУЗ-н хараат бус гишүүнд нэр дэвшигч Б. Лхагвасүрэн: Оноог маш зөв шийдэж өгсөн байна гэж бодож байна. Хэрэглэгчдийг идэвхжүүлэх боломж гэж харж байна.

ТУЗ-н хараат бус гишүүнд нэр дэвшигч Ганбаяр: Апп дээр бичлэгийн линкийг хуулж болохгүй байна энэ талаар мэдээлэл авмаар байна.

ТУЗ-н дарга П. Бүүвэйбаатар: Шэйрлэж болно. Апп дээрээ шэйрлэх тохиргоотой байгаа. 3 сард апп маань эхний ээлжид бүрэн гарна. Тэр үед жижиг алдаанууд засагдсан байдлаар орно.

ТУЗ-н дарга П. Бүүвэйбаатар: Хэлэлцэх асуудал 1 буюу 2025 оны тайланд жилд ноогдол ашиг тараахгүй байх тухай санал хураав.

100 хувьтай санал батлагдав.

ТУЗ-н дарга П. Бүүвэйбаатар: Хэлэлцэх асуудал 2 буюу 2026 оны санхүүгийн жилийн зардлын төсвийг зөвшөөрөх тухай хэлэлцэв.

100 хувьтай санал нийлэв.

ТУЗ-н гишүүн А Цэвэлсүрэн: Хөрөнгийн биржээр босгоно гэсэн тэгэхээр заавал дахин хуралдаж зөвшөөрөл авч батлах уу?

ТУЗ-н дарга П. Бүүвэйбаатар: Бид тухай бүрд санал авч, танилцуулна. Хуулийн дагуу бүгдийг хийж гүйцэтгэх болно.

ТУЗ-н дарга П. Бүүвэйбаатар: Хэлэлцэх асуудал 3 буюу 2026 оны үйл ажиллаганы төлөвлөгөөг батлах тухай санал хураая.

100 хувийн саналтайгаар батлагдав.

ТУЗ-н дарга П. Бүүвэйбаатар: Хэлэлцэх асуудал 4 буюу ТУЗ-ийг сонгох тухай. Одоогийн байдлаар 10 хүний анкет ирсэн байна. Нэр дэвшигчдийг танилцуулав. П.Бүүвэйбаатар, Энхтөр, Эрдэнэбаяр, Г.Уламбаяр, Б.Лхагвасүрэн, Г.Наранзул, Л.Болд, Б. Ганзориг, Б. Ганбаяр нар нэр дэвшив.

ТУЗ-н дарга П. Бүүвэйбаатар: Тооллогын комиссоос гарсан тогтоолыг танилцуулж, олон улсад гарсан технологийн компани болж өргөжиж, ирэх жилд ашиг арвин байж, хувьцааны үнэ өссөн, амжилт бүтээл дүүрэн байг хэмээн талархал илэрхийлж хурал дууссаныг мэдэгдэв.

ТАНИЛЦСАН:
ХУРЛЫН ДАРГА

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:



П. Бүүвэйбаатар

Г. Энхтөр